# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/70 Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Лайт Криестал Интернэшнл ХХК-ийн "Кристал" дэн буудлын 19/326, Туна ХХК-ийн "Дабль-Ю" дэн буудлын 19/342, Дипломат Байгууллага Үйлчилгээ эрхлэх газрын "Дипломат" зочид буудлын 19/305, Нэгдэлч ХХК-ийн "Нэгдэлчин" зочид буудлын 19/306, Цэнтрал Хотел Азиа ХХК-ийн

1150500211

“Централ” зочид буудлын 19/320, Эвээр засах ХХК-ийн “Вашингтон” зочид буудлын 19/321 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА С.БАТБААТАР

5284325 СБТ 2926 1118263502

E:\NAJG\2020\2 A tushaal Tusul\2020.09.08 A70.docx

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 09 сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Эвээр Засах ХХК | 5631858 | Вашингтон | БЗД-ийн, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 41 |
| 2 | Цэнтрал Хотел Азиа ХХК | 6314104 | Цэнтрал | БГД-ийн, 1-р хороо, Магсаржавын гудамж 89 |
| 3 | Нэгдэлч ХХК | 2095688 | Нэгдэлчин | БЗД-ийн, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 33/1 |
| 4 | Дипломат Байгууллага Үйлчилгээ эрхлэх газар | 5112303 | Дипломат | ЧД-ийн, 4-р хороо, Лааганы гудамж |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 09 сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 8920 1118200502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Туна ХХК | 2031078 | Дабль-Ю | СХД-ийн, 19-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж 43-1 |
| 2 | Ган Оюу Шонхор ХХК | 5274261 | Шонхор | СХД-ийн, 4-р хороо, Их Нарангийн 1/1а |
| 3 | Лайт Криестал Интернэшнл ХХК | 5165318 | Кристал | СХД-ийн, 4-р хороо, Их Нарангийн 1/1а |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 09 сарын 08-ны өдрийн А/70 дугаар дугаар тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8926 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|---|---|---|---|---|
| 1 | Ноён Алтай Групп ХХК | 5264219 | Хотол | СБД-ийн, 19-р хороо, Хандгайт1/21-р хэсгийн 2158 |
| 2 | Ивээл Монгол ХХК | 5506387 | Тэрэлж Роял Кемп | НД-ийн, 6-р хороо, Горхийн Баруун Салаа |

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР